

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц”
ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/002-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 7033-3019
Цахим хаяг: Tsetsegdulam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Зорилтот нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. Аудитын тайлан	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	7
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. Аудитын илрүүлэлт	7
5.1 Албан шаардлага	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.21 № 183
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭМАНДАЛ ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.БАТТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд нийт 24,232.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
2. Тайлант хугацааны төлөвлөсөн орлогыг 14.6 хувиар тасалсан, бизнес төлөвлөгөөг батлахдаа орлого зарлагыг ашиг алдагдлыг үндэслэлтэй тооцож, төлөвлөөгүй
3. Төсвийн төлөвлөгөөний зардалд тусгагдаагүй нийт 11,895.3 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.
4. ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нийт 43,032.8 мянган төгрөгийн нүүрсийг шууд худалдан авсан.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.1, 31.1, 34.1, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.7.3, 6.7.6 дахь заалтыг зөрчсөн бөгөөд тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	63,019,226.83	5,013,615.92
4	Дансны авлага	150,000.00	5,979,413.23
8	Бараа материал	7,011,299.00	20,854,428.60
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	70,180,525.83	31,847,457.75
15	Үндсэн хөрөнгө	153,214,597.00	259,578,222.00
23	Биет бус хөрөнгө	2,442,000.00	4,206,000.00
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	155,656,957.00	263,784,222.00
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	225,837,482.83	295,631,679.75
31	Татварын өр	9,356,090.12	9,185,272.93
38	Бусад богино хугацаат өр төлбөр	-	16,333,762.51
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,356,090.12	25,519,035.43
49	Өр төлбөрийн нийт дүн	9,356,090.12	25,519,035.43
51	Өмч: а) төрийн	68,844,000.00	68,844,000.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	147,637,392.71	201,268,644.32
61	Эздийн өмчийн дүн	216,481,392.71	270,112,644.32
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	225,837,992.83	295,631,679.75

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

		/төгрөгөөр/	
Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	462,361,477.27	538,013,649.67
2	Борлуулалтын өртөг	279,573,816.05	286,586,852.18
3	Нийт ашиг	182,787,661.22	251,426,797.49
8	Бусад орлого	37,000,000.00	-
5	Хүүний орлого	-	4,044,074.82
10	Борлуулалт, маркетингийн зардал	143,310,800.00	195,880,592.74
12	Бусад зардал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	76,476,861.22	59,590,279.57
19	Орлогын татварын зардал	7,647,686.12	5,959,027.96
20	Татвар дараах ашиг (алдагдал)	68,829,175.10	53,631,251.61
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	68,829,175.10	53,631,251.61
24	Орлогын нийт дүн	68,829,175.10	53,631,251.61

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
Д/Д	Үзүүлэлт	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл	68,844,000.00	147,637,392.71	216,481,392.71
9	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	68,844,000.00	147,637,902.71	216,481,902.71
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	53,631,251.61	53,631,251.61
17	2024 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	68,844,000.00	201,268,644.32	270,112,644.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/
Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	556,117,625.27	595,859,091.49	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	511,117,625.27	591,815,016.67	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	4,044,074.82	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	37,000,000.00	-	
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,000,000.00	-	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	451,650,359.26	526,737,702.40	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	74,828,448.05	138,041,158.82	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,697,795.95	25,292,565.58	
1.2.3	Бараа материалын худалдан авахад төлсөн	12,002,300.00	15,189,950.00	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	52,867,300.45	59,175,156.43	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	227,954,539.03	235,487,656.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	63,161,275.78	53,047,415.57	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	138,700.00	503,800.00	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	104,467,266.01	69,121,389.09	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,157,000.00	127,127,000.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	64,507,000.00	124,507,000.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,650,000.00	2,620,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-66,157,000.00	127,127,000.00	
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	38,310,266.01	-58,005,610.91	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,708,960.82	63,019,226.83	
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,019,226.83	5,013,615.92	

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 157 мэдээллээс 107 мэдээллийг хугацаанд, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 46 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа¹ 110,005.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ Тайлант онд худалдан авсан 97,799.1 мянган төгрөгийн халаалтын тогоог тайлан балансд барилга байгууламж дансанд буруу ангилан бүртгэснийг залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тайлант оны нүүрсний орлого, зардлын бүртгэлийг бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, няравын тайлантай тулган шалгахад 73.35 тн буюу 3,300.7 төгрөгийн нүүрсийг орлогоор бүртгээгүй, үндсэн түүхий эд материалын орлого 4,503.5 мянган төгрөгөөр, зарлага 4,402.2 мянган төгрөгөөр нийт 8,905.7 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу буруу тусган тайлагнасанд нийт **12,206.5** төгрөгийн залруулга хийлгэлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого", Дүрмийн 8.2-т Газрын санхүүгийн тайлангийн үнэн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй 36,128.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 4 зөрчилтэй асуудал нь 79,161.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 3,497.1 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд НӨАТ-ын өглөг 3,076.9 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 4,822.2 мянган төгрөг, нүүрсний тээврийн хөлс 16,333.7 мянган нийт 24,232.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

5.1.2 "Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.6 дахь заалтыг үндэслэн газар ухах болон шугамын холболт хийсэн орлогын цэвэр ашгаас байгууллагын даргын 2024.10.01-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар 2-25 хувиар тооцон тайлант жилд албан хаагчдад нийт 11,895.3 мянган төгрөгийн хувь олгосон нь төсвийн төлөвлөгөөний зардалд тусгагдаагүй, зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан төсөв, ТУЗ-ийн баталсан 2024 оны "бизнес төлөвлөгөө", Дүрмийн 5.2.3-т Газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.1.3 Тайлант хугацаанд нийт 629,913.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 538,013.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 14.6 хувиар тасалсан, бизнес төлөвлөгөөг батлахдаа орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөгөөгүй, ашиг алдагдлыг тооцоогүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг" 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10-т "Захирал дор дурдсан бүрэн эрхтэй" Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн бизнес төлөвлөгөө болон орлого, зардал, ашиг, алдагдлыг бодиттой тооцоо судалгаанд тулгуурлан эдийн засгийн үндэслэлтэй боловсруулж батлуулах албан шаардлагыг хүргүүлээ.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.4 Тус ОНӨААТҮГ нь тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нийт 43,032.8 мянган төгрөгийн нүүрсийг Баян тээг ХК-аас шууд худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, 34 дүгээр зүйлийн 34.1-д “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” -ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Буруу ангилан бүртгэсэн	1	97,799.1			1	97,799.1	1	97,799.1				
Зөрүүтэй тусгасан	1	8,905.7			1	8,905.7	1	8,905.7				
Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	1	3,300.7	1	3,300.7			1	3,300.7				
Дүн	3	110,005.6	1	3,300.7	2	106,704.8	3	110,005.6				

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
											/мянган төгрөгөөр/	
Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	24,232.9			1	24,232.9						
Зориулалт бус зарцуулсан	1	11,895.3			1	11,895.3						
Биенес төлөвлөөг үндэслэлтэй төлөвлөөгүй	1	0			1	0						
Худалдан авах ажиллагаатай холбоотой	1	43,032.8			1	43,032.8						
дүн	4	79,161.0			4	79,161.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй	1	0			1	0		

